



Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрх:

Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахын өмнөх дараалсан 3 ба түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээ:

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг түүний шимтгэл төлсөн хугацааг харгалзан хөдөлмөрийн чадвар алдахын өмнөх шимтгэл төлсөн сүүлийн дараалсан 3 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас дараах хувь хэмжээгээр тооцно:

Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа (сараар)	Тэтгэмж бодох хэмжээ (хувиар)
3-59	50
60-119	55
120-179	60
180 ба түүнээс дээш	75

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацаа:

- Хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацааны ажлын эхний 5 өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогчоос, 6 дахь өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацааны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас тус тус олгоно.
- Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид тэтгэвэр тогтоолгосон тухайн өвчний оношоор хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгохгүй.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлт илгээх:

Даатгуулагч Та хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлтээ <https://daatguulagch.ndaatgal.mn/> цахим хаягаар нийгмийн даатгалын байгууллагад илгээж болно.

Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичиг (цаасан, эсхүл цахим хэлбэрээр):

- Тэтгэмж авахыг хүссэн өргөдөл;

- Эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас (албан журмаар даатгуулагч эмнэлгийн хуудсыг цахимаар бичүүлсэн тохиолдолд ажил олгогчоос нийгмийн даатгалын байгууллага руу илгээнэ);
- Тэтгэмж авах даатгуулагчийн мэдээлэл (овог, нэр, регистр, банкин дахь дансны дугаар).

Сайн дураар даатгуулагчийн хувьд:

- Эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудсыг харьяалах Нийгмийн даатгалын газарт хүргүүлж, тэтгэмж авах хүсэлтээ гаргана;
- Эмнэлгийн хуудсыг цахимаар бичүүлсэн тохиолдолд Даатгуулагчийн веб (ndaatgal.mn)-ийн тусламжтайгаар тэтгэмж авах хүсэлтээ илгээнэ.

Жишээ: Даатгуулагч 125 сар тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж ажилласан, тэтгэмж авахын өмнөх дараалсан 3 сарын дундаж цалин сард 2 000 000 төгрөг, ажлын 12 өдөр хөдөлмөрийн чадвараа түр алдсан, сүүлийн 3 сарын ажлын дундаж өдрийн тоо 21 гэвэл:

Бодолт: а) Сүүлийн 3 сарын ажлын дундаж өдрийн тоо: **21 өдөр**

б) Шимтгэл төлсөн хугацаанд ногдох хувь: **60%**

б) Нэг өдөрт ногдох хөдөлмөрийн хөлс, орлого: $(2,000,000\text{₮} * 60\%) : 21 \text{ өдөр} = 57,143\text{₮}$

в) Тэтгэмж олгох хоног: **12 өдөр** (эмнэлгийн хуудсанд бичигдсэн хугацаан дахь ажлын өдрөөр тооцно)

г) Олговол зохих тэтгэмж: $57,143\text{₮} * 12 \text{ өдөр} = 685,714\text{₮}$